

## ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2008 оны 3 дугаар сарын 23 -ны өдөр хот

Дугаар 1

Улаанбаатар

### **Химийн хорт бодисын осолтой холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Баянгол дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт Тэн хун ХХК өөрийн эзэмшлийн байранд хууль бусаар хадгалж байсан мөнгөн ус асгарч, алдагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, Үндэсний зөвлөлийн шинжээчдийн багийн зөвлөмжийн талаар хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Химийн хорт болон аюултай бодисын худалдаа, ашиглалтын далд сүлжээг илрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, химийн хорт болон аюултай бодисын аюул ослын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж, танилцуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Химийн хорт болон аюултай бодисын худалдаа, ашиглалтын далд сүлжээг илрүүлэх ажлын хэсгийн удирдамж, төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах зардлыг гаргаж ажиллах, Байгаль орчны яамнаас бэлтгэсэн мөнгөн усны сэрэмжлүүлгийг Монголын үндэсний телевизээр байнга явуулах ажлыг зохион байгуулахыг Шинжээчдийн багийн ахлагч, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Т.Гантулга/-д даалгасугай.

3. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлийн 5 дахь заалт, 2008 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалтад заасан аюултай хог хаягдлыг устгах, хадгалах төвлөрсөн байгууламжийг олон улсын стандартын дагуу байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, холбогдох зардлын тооцоог гаргаж, шийдвэрлүүлэхийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга/Ц.Амгаланбаяр/, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Т.Гантулга/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга/Д.Баттөр/, Нийслэлийн Засаг дарга/Т.Билэгт/ нарт тус тус даалгасугай.

4. Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн байнгын ажлын албыг байгуулж, 4 дүгээр сарын 1-ээс үйл ажиллагааг эхлүүлэхийг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Т.Гантулга/-д даалгасугай.

5. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн дэргэдэх Шинжээчдийн багийн 2008 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаас гаргасан зөвлөмжийг зүйтэй гэж үзэж, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга/Ц.Амгаланбаяр/, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга /Ц.Шийрэвдамба/ нарт тус тус даалгасугай.

6. Баянгол дүүргийн 1-р хорооны 20 дугаар байрны оршин суугчдад бохирдлыг арилгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өгөхийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга /Ц.Амгаланбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА,  
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД Г.ШИЙЛЭГДАМБА  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Л.ЖАРГАЛСАЙХАН

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн 2008 оны дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Химийн хорт болон аюултай бодисын худалдаа, ашиглалтын далд сүлжээг илрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн **Ажлын хэсгийн ахлагч:** БОЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулга **Гишүүд:** Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дэд дарга, хурандаа Д.Батжаргал Тагнуулын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Г.Алтансүх Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд дарга Б.Баасан Гаалийн ерөнхий газрын дэд дарга Д.Оюунчимэг Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга бөгөөд Гамшигтай тэмцэх газрын дарга, комиссар Д.Намсрай Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны дарга М.Мөрөн **Нарийн бичгийн дарга:** БОЯ-ны ХБОБНГ-ын мэргэжилтэн Ш.Дагва

---

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн 2008 оны дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Химийн хорт болон аюултай бодисын аюул ослын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн **Ажлын хэсгийн ахлагч:** Онцгой байдлын ерөнхий газрын Гамшигтай тэмцэх газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн дарга Ч.Батчулуун **Гишүүд:** Байгаль орчны яам хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газрын дарга Ц.Банзрагч Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Бүжин ХХААЯ-ны мэргэжилтэн Б.Мэнджаргал ХХААЯ-ны Мал эмнэлэгийн газрын орлогч дарга . Доржсүрэн ҮХЯ-ны газрын орлогч дарга .Нэргүй ҮХЯ-ны мэргэжилтэн Д. Амаржаргал Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дэд дарга, хурандаа Д.Батжаргал Зам тээвэр аялал жуулчлалын яамны Тээврийн газрын дарга Д.Наранпүрэв Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын ажилтан, ахмад О.Цэнгэлбаатар Тагнуулын ерөнхий газрын ажилтан, ахмад М.Хангай Байгаль орчны яамны Хүрээлэн буй орчин , байгалийн нөөцийн газрын ахлах мэргэжилтэн Ш.Дагва Улсын мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч З.Отгон Онцгой байдлын ерөнхий газрын Гамшигтай тэмцэх газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах шуурхай удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Г.Буянтогтох **Нарийн бичгийн дарга:** Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Л.Жаргалсайхан